



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 1/68

Мандалговь

Г
Э.Насандэлгэрийг Эрдэнэдалай сумын
Эрүүл мэндийн төвийн даргын албан
тушаалд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн Үйлчилгээний байгууллагын Төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 2 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Эрдэнэдалай сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Эрдэнэбаяр овогтой Насандэлгэр 79 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Э.Насандэлгэрийн холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албандаа даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛООН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2023 оны 18 дугаар сарын
05.-ны өдрийн 10 дугаар тогтоолын хавсралт



**Эрдэнэдалай сумын Эрүүл мэндийн төвийн даргын
албан тушаалд нэр дэвшүүлсэн Э.Насандэлгэрийн тухай
дүгнэлт**

1. Э.Насандэлгэр нь 1991 онд Дундговь аймгийн Эрдэнэдалай суманд төрсөн. 32 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2009-2015 онд Дорноговь аймаг дахь АШУҮИС-ийг Хүний их эмч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. 2016 оноос Эрдэнэдалай сумын Сумын дундын эмнэлэгт 5 дугаар багийн эмч, эх барих эмэгтэйчүүдийн эмч, даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр тус тус ажиллаж байсан.
4. Э.Насандэлгэрийн төрийн албаны дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Эрдэнэдалай сумын Сум дундын эмнэлгийн даргын албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ